

2024

ЭХНИЙ ХАГАС ЖИЛ

/Урьдчилсан гүйцэтгэлээр/



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

ЗАМ ТЭЭВЭР



СТАТИСТИКИЙН ЭМХЭТГЭЛ

СУДАЛГАА, СТАНДАРТ,
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2024 ОН

0

АГУУЛГА

ДҮГНЭЛТ.....	5
БҮЛЭГ 1. САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	7
Ачаа тээвэр	7
Зорчигч тээвэр.....	11
БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР.....	14
Зорчигч тээвэр.....	14
Ачаа тээвэр	15
Тээврийн хэрэгслийн бүртгэл.....	18
БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР.....	22
Зорчигч тээвэр.....	22
Ачаа тээвэр	23
БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР.....	27
Зорчигч тээвэр.....	27
Ачаа тээвэр	30
Нислэгийн үзүүлэлт.....	31
ХАВСРАЛТ.....	32

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Ачаа тээвэр, эхний хагас жил	7
Зураг 2 Ачаа тээврийн өөрчлөлт.....	7
Зураг 3 Тээврийн салбарын эзлэх жин.....	8
Зураг 4 Ачаа эргэлт, сая.тонн/км.....	8
Зураг 5 Ачаа тээвэр, эдийн засгийн салбараар.....	8
Зураг 6 Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт.....	8
Зураг 7 Ачаа тээврийн хэмжээ, хүлээгдэж буй гүйцэтгэлээр	9
Зураг 8 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин	9
Зураг 9 Дотоодын тээвэрлэлтийн эзлэх жин	9
Зураг 10 Тээвэрлэлийн төрөл, салбараар.....	10
Зураг 11 Улс хоорондын ачаа тээвэр.....	10
Зураг 12 Зорчигч тээвэр.....	11
Зураг 13 Зорчигч тээврийн өөрчлөлт.....	12
Зураг 14 Зорчигч тээврийн эзлэх хувь.....	12
Зураг 15 Олон улсын зорчигч тээвэр	12
Зураг 16 Орон нутгийн зорчигч тээвэр.....	12
Зураг 17 Зорчигч эргэлт, сая хүн/км.....	13
Зураг 18 Автотээврийн зорчигч, сая хүн	14
Зураг 19 Олон улс, орон нутгийн зорчигч тээвэр	14
Зураг 20 Автотээврийн зорчигч эргэлт.....	14
Зураг 21 Автотээврийн ачаа тээвэр	15
Зураг 22 Автотээврийн экспортын ачаа.....	16
Зураг 23 Экспортын ачаа эзлэх хувь.....	16
Зураг 24 Автотээврийн импортын ачаа	16
Зураг 25 Боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгсэл, эзлэх хувь	17
Зураг 26 Тээврийн хэрэгслийн ангилал	18
Зураг 27 Жолооны хүрдний байрлал	18
Зураг 28 Хөдөлгүүрийн багтаамж.....	18
Зураг 29 Автомашины насжилт	19
Зураг 30 Орон нутаг дахь тээврийн хэрэгслийн төрөл.....	21
Зураг 31 Төмөр замын зорчигч	22
Зураг 32 Төмөр замаар зорчсон зорчигчдын тоо, хоногоор	22
Зураг 33 Төмөр замын ачаа тээвэр.....	23
Зураг 34 Төмөр замын тээвэрлэлтэд эзлэх хувь	23
Зураг 35 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин	24
Зураг 36 Төмөр замаар тээсэн ачааны төрөл.....	24
Зураг 37 Дотоодын ачаа байгууллагаар.....	24
Зураг 38 Уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрөл	24
Зураг 39 Хүлээн авсан вагон	25
Зураг 40 Хүлээлгэн өгсөн вагон.....	25
Зураг 41 Вагон солилцоо, хилийн өртөөгөөр.....	26
Зураг 42 Хөдлөх бүрэлдэхүүний төрөл.....	26
Зураг 43 Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч.....	26
Зураг 44 Агаарын тээврийн зорчигч	27
Зураг 45 Олон улс, орон нутагт зорчигчдын эзлэх хувь	27
Зураг 46 Зорчигч тээврийн үзүүлэлтүүд	27
Зураг 47 Олон улсын зорчигч, чиглэлээр	28
Зураг 48 Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгчээр	28
Зураг 49 Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....	29
Зураг 50 Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгчээр	29

Зураг 51 Агаарын тээврийн ачаа, шуудан	30
Зураг 52 Ачаа, шуудангийн эзлэх хувь.....	30
Зураг 53 Ачаа тээврийн үзүүлэлт	30
Зураг 54 Нислэгийн үзүүлэлт	31

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Үзүүлэлт	Тодорхойлолт*
Тээсэн ачаа	Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ.
Ачаа эргэлт	Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.
Тээсэн зорчигч	Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.
Зорчигч эргэлт	Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.
Шилжүүлсэн тн.км	Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километр шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.
Тээврийн орлого	Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.

*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

Хянасан:

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн дарга Ц.Мядагмаа

Боловсруулсан:

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Нэмэхжаргал

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн мэргэжилтэн Э.Энхзаяа

Энэхүү эмхэтгэлийг яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ¹ бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн урьдчилсан гүйцэтгэлээр гаргалаа.

¹ Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформыг 2022 оны 1 дүгээр сараас хөгжүүлж эхэлсэн.

ДҮГНЭЛТ

Ачаа тээвэр

2024 оны эхний хагас жилд бүх төрлийн тээврээр нийт 62.9 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.3%-аар өссөн.

Автотээврийн ачаа 41.8 сая тонн болж өмнөх оноос 37%-аар, төмөр замын тээврийн ачаа 21 сая тонн болж өмнөх оноос 24%-аар, агаарын тээврийн ачаа 4.6 мянган тонн болж өмнөх оноос 12.8%-аар тус тус өссөн байна.

Нийт ачаа тээврийн 66.51%-ийг автотээвэр, 33.48%-ийг төмөр замын тээвэр, 0.01%-ийг агаарын тээврийн ачаа эзэлж байна.

Бүх төрлийн тээврээр тээвэрлэсэн экспортын ачаа нийт ачаа тээврийн 73.2%-ийг эзэлж байгаа бөгөөд 2024 оны эхний хагас жилд 45.9 сая тонн болж өмнөх оноос 33.3%-аар өссөн үзүүлэлттэй байна.

2024 оны эхний хагас жилд бүх төрлийн тээврийн хэрэгслээр тээсэн дотоодын ачаа 11.1 сая тонн болж өмнөх оноос 55.4%, төмөр замаар дамжин өнгөрөх транзит тээврийн хэмжээ 2.7 сая тонн болж өмнөх оноос 9.7%-аар тус тус өссөн бол импортын ачаа 3.2 сая тонн болж өмнөх оноос 8.6%-аар буурсан үзүүлэлттэй байна.

2023 оны эхний хагас жилд улс хоорондын ачаа тээвэр 40.4 сая тонн болж нийт ачаа тээврийн 85%-ийг эзэлж байсан бол 2024 онд 51.8 сая тонн болж нийт ачаа тээврийн 82.4% болсон байна.

Эхний хагас жилийн байдлаар төмөр замаар дотоодод тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамгийн их өсөлт үзүүлсэн бол нийт импортын хэмжээ бууралттай гарсан шалтгаан нь Замын-Үүд, Алтанбулаг, Боршоо, Цагааннуур, Хавирга боомтуудаас бусад боомтуудын импортын ачаа буурсан нь голлон нөлөөлжээ.

Нийт ачаа эргэлт 16,097 сая тонн.км болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.1%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Зорчигч тээвэр

2024 оны эхний хагас жилд бүх төрлийн тээврээр нийт 74.9 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 2.4%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр зорчигчдын тоо 2024 онд 71.9 сая болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.2%-аар өссөн байна.

Харин 2024 оны эхний хагас жилд бүх төрлийн тээврээр олон улс болон орон нутагт зорчигчдын тоо 2.9 сая болж өмнөх оноос 5.5%-аар өслөө. Үүнээс агаарын тээврээр 930 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 31.3%, автотээврээр 1.1 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 8.5%-аар тус тус өссөн бол төмөр замаар 921 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 14.3%-аар буурчээ.

Төмөр замаар олон улсад зорчигчдын тоо 19.5 мянга хүрч өмнөх оны мөн үеэс 2.1 дахин нэмэгдсэн боловч орон нутгийн зорчигч 901.5 мянга болж өмнөх оноос 15.5%-аар буурсан нь төмөр замын нийт зорчигчийн тоо буурахад голлон нөлөөлжээ.

Автотээврээр орон нутагт зорчих иргэдийн тоо 871.7 мянга хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.9%-аар өссөнч олон улсад зорчих иргэдийн тоо 268 мянга болж 18.6%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Агаарын тээврээр олон улсад зорчих иргэдийн тоо 726.7 мянга болж 39.7%-аар өссөн нь нийт олон улсад зорчигчийн тоо нэмэгдэхэд голлон нөлөөлжээ.

Зорчигч эргэлт 3,603 сая хүн.км болж өмнөх оны мөн үеэс 20%-аар өсжээ.

АЧАА ТЭЭВЭР

4.6

МЯНГАН
ТОНН

Өмнөх оны мөн
үеэс 12.8% ↑



41.8

САЯ ТОНН

Өмнөх оны мөн
үеэс 37% ↑

- Экспорт- 40.6 сая тн (+41.1%)
- Импорт- 1.2 сая тн (-31.4%)



21.0

САЯ ТОНН

Өмнөх оны мөн
үеэс 24% ↑

- Орон нутгийн- 11 сая.тн (+55.4)
- Экспорт- 5.4 сая.тн (-6.2%)
- Дамжин өнгөрөлт- 2.7 сая.тн (+9.7)
- Импорт- 1.9 сая.тн (+14.9%)



2024
ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛД

НИЙТ 62.9 САЯ ТОНН

Өмнөх оны мөн
үеэс 32.3% ↑

- Орон нутгийн- 11.1 сая.тн (+55.4)
- Экспорт- 45.9 сая.тн (+33.3%)
- Дамжин өнгөрөлт- 2.7 сая.тн (+9.7)
- Импорт- 3.2 сая.тн (-8.6%)



БҮЛЭГ 1. САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ 62.9 САЯ ТОНН БОЛЛОО.


Ачаа тээвэр

Бүх төрлийн тээврээр 2024 оны эхний хагас жилд нийт 62.9 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос 32.3%-аар өслөө. Үүнээс автотээврийн ачаа 41.8 сая тонн болж өмнөх оноос 37%-аар, төмөр замын тээврийн ачаа 21 сая тонн болж өмнөх оноос 24%-аар, агаарын тээврийн ачаа 4.6 мянган тонн болж өмнөх оноос 12.8%-аар тус тус өссөн байна.

Нийт ачаа эргэлт 2023 оны эхний хагас жилд 14.1 сая.тн/км байсан бол 2024 оны эхний хагас жилд 16.1 сая.тн/км болж 14.1%-аар өслөө.


Өмнөх онуудын эхний хагас жилд тээвэрлэсэн ачааны хэмжээг доорх хүснэгтэд харуулав.

Зураг 1 Ачаа тээвэр, эхний хагас жил



Тээврийн төрөл	2020	2021	2022	2023	2024
Нийт тээсэн ачаа, мянган тонн	22,803.8	27,630.1	21,870.4	47,503.7	62,857.2
Төмөр зам	14,384.4	15,930.3	12,661.9	16,972.7	21,043.2
Автотээвэр	8,418.0	11,697.8	9,202.0	30,526.9	41,809.4
Агаарын тээвэр	1.4	1.9	6.5	4.1	4.6
Нийт ачаа эргэлт, сая.тн/км	23,861.0	20,674.6	17,534.1	29,512.7	16,097.0
Төмөр зам	9,191.3	9,486.1	6,678.4	9,275.0	10,247.2
Автотээвэр	1,108.4	1,531.0	880.6	4,818.9	5,835.1
Агаарын тээвэр	4.6	4.9	15.2	11.6	14.7


Зураг 1 Ачаа тээврийн өөрчлөлт



Монгол Улс өнөөдөр хоёр хөрштэйгөө төмөр замын 3 боомт, авто замын 13 боомтоор экспорт, импортын тээвэр хийж байна.

2023 оны эхний хагас жилд нийт ачаа тээврийн дүнд автотээвэр 64.26%, төмөр замын тээвэр 35.73%, агаарын тээвэр 0.01%-ийг тус тус эзэлж байсан бол 2024 онд 66.51%-ийг автотээвэр, 33.47%-ийг төмөр замын тээвэр, 0.02%-ийг агаарын тээврийн ачаа эзэлж байна.

Зураг 2 Тээврийн салбарын эзлэх жин




Нийт ачаа эргэлт 16,097 сая.тн/км болж 2020 оны түвшингээс 56%-аар, 2021 оноос 46%-аар, 2022 оноос 2.1 дахин өссөн бол өмнөх оны мөн үеэс 14.1%-аар өсчээ.

Автотээврийн ачаа эргэлт 2024 оны эхний хагас жилд 5,835.1 сая.тн/км болж өмнөх оноос 21.1%-аар, 2020 онтой харьцуулахад 5 дахин өслөө.

Нийт ачаа эргэлтэд төмөр замын ачаа эргэлт хамгийн өндөр үзүүлэлттэй хэвээр байна. 2024 оны эхний хагас жилд 10,247.2 сая.тн/км болж өмнөх оноос 10.5%, 2020 оны түвшингээс 11.5%-аар өсчээ.

Зураг 3 Ачаа эргэлт, сая.тонн/км




2023 онд автотээврээр тээвэрлэсэн ачааны 95.7%, төмөр замаар тээвэрлэсэн ачааны 43.3% нь уул уурхайн бүтээгдэхүүн байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн 81.4% буюу 40 сая тонн ачааг автотээврээр, 18.6% буюу 9.1 сая тонн ачааг төмөр замаар тээвэрлэсэн байна.


Ачаа тээврийг эдийн салбараар ангилбал, 2024 оны эхний хагас жилд нийт 62.2 сая тонн ачаа тээвэрлэснээс 56.6 сая тонн буюу 90%-ийг уул уурхайн салбарын бүтээгдэхүүн, 1.9 сая тонн буюу 3%-ийг барилгын салбарын бүтээгдэхүүн, 1.2 сая тонн буюу 2%-ийг хүнс хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, 3.2 сая тонн буюу 5%-ийг бусад салбарын ачаа эзэлж байна.

Зураг 4 Ачаа тээвэр, эдийн засгийн салбараар




Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийг бүтээгдэхүүнээр авч үзвэл, 45.1 сая тонн буюу 91.8%-ийг нүүрс, 3.1 сая тонн буюу 6.3%-ийг төмрийн хүдэр, 0.7 сая тонн буюу 1.5%-ийг зэсийн баяжмал, 218 мянган тонн буюу 0.4%-ийг газрын тос, 46.3 мянган тонн буюу 0.09%-ийг жонш тус тус эзэлж байна.

Зураг 5 Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт



Зураг 6 Ачаа тээврийн хэмжээ, хүлээгдэж буй гүйцэтгэл



Үзүүлэлт	Тээврийн төрөл	2023 он	2024 он
Нийт тээсэн ачаа, сая тонн			
		47,503.7	62,857.2
Транзит	Төмөр зам	2,422.0	2,656.0
Экспорт	Төмөр зам	5,735.9	5,379.2
	Автотээвэр	28,775.8	40,607.9
	Нийт	34,511.7	45,987.1
Импорт	Төмөр зам	1,706.7	1,960.2
	Автотээвэр	1,751.1	1,201.5
	Нийт	3,457.8	3,161.7
Дотоодод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	7,108.1	11,047.7
	Агаар	4.08	4.60
	Нийт	7,112.2	11,052.3

Бүх төрлийн тээврээр тээсэн экспортын ачаа 45.9 сая тонн болж өмнөх оноос 33.3%-аар, дотоодын ачаа 11.1 сая тонн болж өмнөх оноос 55.4%, төмөр замаар дамжин өнгөрөх транзит тээврийн хэмжээ 2.7 сая тонн болж өмнөх оноос 9.7%-аар тус тус өссөн бол импортын ачаа 3.2 сая тонн болж өмнөх оноос 8.6%-аар буурсан байна.

Зураг 7 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин




2023 оны эхний хагас жилийн байдлаар 72.7%-ийг эзэлж байсан экспортын тээвэр 73.2% болж өссөн бол импортын ачаа нийт тээврийн хэмжээнд эзлэх хувь 7.3%-аас 5% болж өөрчлөгджээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх төмөр замын транзит тээврийн эзлэх хувь 4.2% байна.

Дотоодын ачаа тээвэр 2023 оны эхний хагас жилд 7.1 сая тонн буюу нийт ачаа тээврийн 14.9%-ийг эзэлж байсан бол 2024 онд 11.1 сая тонн болж өссөн нь 17.6%-ийг эзэлжээ.

Зураг 8 Дотоодын тээвэрлэлтийн эзлэх жин




Төмөр замын байгууллагууд эрчим хүчний нүүрс, шахмал түлшний түүхий эдийн тээврийг бүрэн хариуцан нийгмийн хариуцлагын хүрээнд тээвэрлэсэн нь дотоодын ачааны есөлтөд нөлөөлжээ.

Дотоодод тээвэрлэсэн 11.1 сая тонн ачааны 5.9 сая тонн ачаа буюу 53.8%-ийг “Улаанбаатар төмөр зам” ХНН, 1.2 сая тонн ачаа буюу 10.9%-ийг “Монголын төмөр зам”

ТӨХК, 1.7 сая тонн ачаа буюу 15.2%-ийг “Тавантолгой төмөр зам” ХХК, “Монголиантранс Логистик” ХХК 1.8 сая тонн буюу 16.6%-ийг, “Монголиантранс Лайн” ХХК 522.2 мянган тонн буюу 4.7%-ийг тус тус эзэлж байна.

Зураг 9 Тээвэрлэлтийн төрөл, салбараар




Улс хоорондын ачаа тээвэр буюу экспорт, импортын ачаа тээврийг төмөр зам, автотээвэрээр гүйцэтгэж байгаа бол транзит тээвэр болон дотоодын тээвэрт төмөр зам голлох үүрэг гүйцэтгэж байна.

2024 оны эхний хагас жилд автотээвэрээр экспортын ачааны 88.3%, импортын ачааны 38%-ийг тээсэн бол төмөр замаар транзит ачааг 100%, дотоодын ачааны 99.9%, импортын ачааны 62%, экспортын ачааны 11.7%-ийг тээвэрлэжээ.

2023 оны эхний хагас жилд улс хоорондын ачаа тээвэр 40.4 сая тонн болж нийт ачаа тээврийн 85%-ийг эзэлж байсан бол 2024 оны эхний хагас жилд 51.8 сая тонн болж нийт ачаа тээврийн 82.4% болжээ.

2024 оны эхний хагас жилд Гашуунсухайт боомтоор хамгийн их буюу 20.6 сая тонн ачаа гарсан нь нийт ачаа гаргалтын 44.8%-ийг эзэлж байгаа бол Шивээхүрэн боомтоор 25%-ийн ачаа, Ханги боомтоор 9%-ийн ачаа гарчээ.

Зураг 11 Улс хоорондын ачаа




Улс хоорондын ачаа тээврийн дүнд экспорт 89%, импорт 6%, дамжин өнгөрсөн ачаа 5%-ийг эзэлж байна.

Экспортын ачааны 40.6 сая тонн буюу 88.3%-ийг автотээвэрээр тээвэрлэсэн нь өмнөх оноос 41.1%-аар өссөн бол төмөр замаар 5.4 сая тонн буюу 11.7%-ийг тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 6.2%-аар буурсан байна. Энэхүү бууралтад төмөр замаар тээвэрлэсэн уул уурхайн ачаа болох нүүрс, зэсийн баяжмал, цайрын баяжмалын бууралт голлон нөлөөлжээ.

Импортын ачааны 1.9 сая тонн ачаа буюу 62%-ийг төмөр замаар тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 14.9%-аар өссөн бол 1.2 сая тонн буюу 38% ачааг автотээвэрээр тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 31.4%-аар буурсан байна. Энэхүү бууралтын гол шалтгаан нь Замын-Үүд, Алтанбулаг, Боршоо, Цагааннуур боомтуудаас бусад боомтуудын импортын ачаа буурсан нь голлон нөлөөлжээ.

2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРЭЭР **74.9 САЯ** ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛЭЭ.

Зураг 12 Зорчигч тээвэр, эхний хагас жил



Зорчигч тээвэр

Бүх төрлийн тээвэрээр 2024 оны эхний хагас жилд нийт 74.9 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 2.4%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээвэрээр зорчигчдын тоо 71.9 сая байна.

Үүнээс агаарын тээвэрээр 930 мянган зорчигч тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 31.3%, автотээвэрээр 73.1 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 2.3%-аар тус тус өссөн бол төмөр замаар 921 мянган зорчигч тээвэрлэж өмнөх оноос 14.3%-аар буурсан байна.

Тээврийн төрөл	2020	2021	2022	2023	2024
Нийт зорчигчдын тоо, мян.хүн	33,344.6	26,858.8	68,869.3	73,252.3	74,989.5
Автотээвэр	32,160.0	26,800.0	67,500.0	71,469.1	73,138.5
Төмөр замын тээвэр	887.6	0.3	1,045.8	1,074.9	921.0
Агаарын тээвэр	297.0	58.5	323.5	708.3	930.0
Зорчигч эргэлт, сая хүн/км	1,254.1	335.3	1,839.3	3,002.2	3,603.5
Автотээвэр	488.4	245.1	864.0	1,036.7	1,050.6
Төмөр замын тээвэр	271.9	0.0	303.6	384.5	382.8
Агаарын тээвэр	493.8	90.2	671.7	1,581.0	2,170.1

921.0

мянган хүн (-14.3%)



930.0

мянган хүн (+31.3%)



73.1


сая хүн (+2.3%)



Үзүүлэлт	Тээврийн төрөл	2023 он	2024 он
Нийт зорчигч, мян.хүн		73,252.4	74,989.5
Олон улсад зорчигч	Автотээвэр	329.3	268.0
	Төмөр зам	8.0	19.5
	Агаарын тээвэр	520.2	726.7
	Нийт	857.5	1,014.2
Орон нутагт зорчигч	Автотээвэр	721.0	871.7
	Төмөр зам	1,066.9	901.5
	Агаарын тээвэр	188.2	203.3
	Нийт	1,976.1	1,976.5
Нийслэлд зорчигч	Автотээвэр	70,418.8	71,998.8

2024 оны эхний хагас жилд бүх төрлийн тээврээр улс хооронд болон хот хооронд зорчсон зорчигчдын тоо 2.9 сая болж өмнөх оноос 5.5%-аар өслөө.


Зураг 13 Зорчигч тээврийн өөрчлөлт




Үүнээс агаарын тээврээр 930 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 31.3%, автотээврээр 1.1 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 8.5%-аар тус тус өссөн бол төмөр замаар 921 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 14.3%-аар буурсан байна.

Тээврийн төрлөөр авч үзвэл, автотээврээр 38.1%, төмөр замаар 30.8%, агаарын тээврээр 31.1% нь зорчсон байна.

Зураг 14 Зорчигч тээврийн эзлэх хувь



Зураг 105 Олон улсын зорчигч тээвэр




Олон улсад зорчигчдын тоо 1 сая болж өмнөх оны мөн үеэс 18.3%-аар өссөн. Үүнээс агаарын тээврээр олон улсад зорчигчдын тоо 726.7 мянган болж өмнөх оноос 39.7%-аар өссөн нь нийт олон улсад зорчигчдын 71.7%-ийг эзэлж байна. Төмөр замаар зорчигчийн тоо нийт олон улсад зорчигчийн 2%-ийг, автотээврээр зорчигчийн тоо 26%-ийг эзэлж байна.

Төмөр замаар олон улсад 19.5 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 2.1 дахин өссөн. Харин автотээврээр олон улсад зорчигчдын тоо 2023 оны эхний хагас жилд онд 329.3 мянга байсан бол 268 мянга болж өмнөх оноос 18.6%-аар буурсан.

Бүх төрлийн тээврээр орон нутагт зорчигчдын тоо 2024 оны эхний хагас жилд 1.9 сая болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.02%-аар өссөн байна.

Зураг 16 Орон нутгийн зорчигч тээвэр




2024 оны эхний хагас жилд автотээврээр 871.7 мянган зорчигч орон нутагт тээвэрлэсэн нь нийт орон нутгийн зорчигч тээврийн 44.1%-ийг, төмөр замын тээврээр 901.5 мянган зорчигч буюу 45.6%-ийг, агаарын тээврээр 203.3 мянган зорчигч буюу 10.3%-ийг эзэлж байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчсон зорчигчийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8%-аар, автээврээр зорчсон зорчигчийн тоо 20.9%-аар өссөн бол төмөр замын орон нутгийн зорчигчдын тоо өмнөх оноос 15.5%-аар буурсан. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам баригдаж хөдөлгөөн нээсэн, мөн төмөр замын зорчигч тээврийн тариф 50 хүртэл хувиар нэмэгдсэн нь төмөр замын орон нутгийн зорчигчийн тоо бууралтад нөлөөлжээ.

2024 оны эхний хагас жилд нийт зорчигч эргэлт 3,603 сая хүн/км болж өмнөх оноос 20%-аар өсчээ. Үүнээс агаарын тээврийн зорчигч эргэлт хамгийн өндөр хувиар буюу 37.3%-аар өсч, 2,170 сая хүн/км болжээ.

Зураг 117 Зорчигч эргэлт, сая хүн/км



БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР


АВТОТЭЭВРЭЭР УЛС, ХОТ ХООРОНД БОЛОН ХОТ ДОТОР НИЙТ 73.1 САЯ ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛЭЭ.

Зорчигч тээвэр

2024 оны эхний хагас жилд автотээврээр нийт 73.1 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 2.3%-аар, зорчигч эргэлт 1050.6 сая хүн/км болж 1.3%-аар тус тус өссөн байна. Үүнд нийслэлийн нийтийн тээврээр 71.9 сая зорчигч зорчиж өмнөх оноос 2.2%-аар өссөн нь нөлөөлжээ.


Хот хооронд буу орон нутагт 871.7 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 20.9%-аар өссөн бол автотээврээр олон улсад 268 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 18.6%-аар буурсан байна.

Зураг 1812 Автотээврийн зорчигч, сая хүн




Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2023 он	2024 он	2024/2023
Нийт зорчигч тээвэр	хүн	71,469,126	73,138,482	2.3%
Олон улсад зорчигчид	хүн	329,315	268,022	-18.6%
Хот хоорондын зорчигч	хүн	721,006	871,695	20.9%
Хот доторх нийтийн тээврээр зорчигч	хүн	70,418,805	71,998,765	2.2%
Зорчигч эргэлт	сая.хүн/км	1,036.7	1,050.6	1.3%

Зураг 1913 Олон улс, орон нутгийн зорчигч тээвэр



Хөдөө орон нутгийн авто замын чанар сайжирч хатуу хучилттай авто зам нэмэгдсэнээр орон нутагт зорчих иргэдийн тоо нэмэгдсэн нь орон нутгийн зорчигчийн тоо өсөхөд голлон нөлөөлжээ.


Зураг 20 Автотээврийн зорчигч эргэлт



Нийслэлийн нийтийн тээврээр зорчигчдын тоо тогтмол өсч байгаа нь автотээврийн зорчигч эргэлт өсөхөд голлон нөлөөлжээ. Автотээврийн зорчигч эргэлт нийт зорчигч эргэлтийн 29.2%-ийг эзэлж байна.

АВТО ЗАМЫН ХИЛИЙН БООМТООР АВТОТЭЭВРЭЭР 41.8 САЯ ТОНН АЧАА ТЭЭВЭРЛЭЖ 37 ХУВИАР ӨСЛӨӨ.

Зураг 21 Автотээврийн ачаа тээвэр



Ачаа тээвэр

2024 оны эхний хагас жилд авто замын боомтуудаар нийт 41.8 сая тонн ачаа тээвэрлэсэн өмнөх оноос 37%-аар өссөн бөгөөд үүнээс нийт 40.6 сая тонн экспортын ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 41.1%-аар өссөн бол 1.2 сая тонн импортын ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 31.4%-аар буурсан байна.

Автотээврийн ачаа тээвэр	Хэмжих нэгж	2023 он	2024 он	2024/2023
Нийт тээсэн ачаа	тонн	30,526,897.0	41,809,386.7	37.0%
Ачаа оруулалт - импорт	тонн	1,751,143.0	1,201,520.2	-31.4%
БНХАУ-аас	тонн	1,590,657.0	1,001,783.2	-37.0%
ОХУ-аас	тонн	160,486.0	199,737.0	24.5%
Ачаа гаргалт - экспорт	тонн	28,775,754.0	40,607,866.5	41.1%
БНХАУ руу	тонн	28,687,640.0	40,587,746.5	41.5%
ОХУ руу	тонн	88,114.0	20,120.0	-77.2%
Ачаа эргэлт	сая.тонн/км	4,818.9	5,835.1	21.1%

2024 онд тээсэн нийт экспортын ачааны 88%-ийг автотээвэрээр тээжээ.

Зураг 2214 Автотээврийн экспортын ачаа




Автотээврийн экспортын ачааны 99.9%-ийг БНХАУ руу тээвэрлэсэн бол, 0.1%-ийг ОХУ руу тээвэрлэжээ.

Гашуунсухайт боомтоор хамгийн их 50.7% буюу 20.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 31.1%, Шивээхүрэн боомтоор 28.4% буюу 11.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 70.6%, Ханги боомтоор 9.8% буюу 4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 72.7%, Бичигт боомтоор 3% буюу 1.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 16.9%, Булган боомтоор 4% буюу 1.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 16.6%-аар, Замын-Үүд боомтоор автотээврийн экспортын ачааны 2.4% буюу 972.3 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 89.5%-аар тус тус өсчээ.

ОХУ-тай хиллэдэг Алтанбулаг боомтоор 20.1 мянган тонн ачаа экспортод тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 27.9%-аар буурсан байна.

Зураг 23 Экспортын ачаа, эзлэх хувь



2024 оны эхний хагас жилд автотээврээр 38.9 сая тонн нүүрс (+43.0%), 479.3 мянган тонн зэсийн баяжмал (+37.5%), 358.8 мянган тонн төмрийн хүдэр (*2.6 дахин), жонш 46.3 мянган тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байгаа бол 218.3 мянган тонн газрын тос (-25.5%), 599.9 мянган тонн бусад ачаа (-29.9%) тээвэрлэсэн нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

Ачааны нэр төрлөөр	Хэмжих нэгж	2023 он	2024 он	2024/2023
Нүүрс	тонн	27,203,435.7	38,905,248.0	43.0%
Газрын тос	тонн	292,964.9	218,311.0	-25.5%
Зэсийн баяжмал	тонн	348,480.0	479,262.0	37.5%
Төмрийн хүдэр	тонн	136,638.7	358,817.0	162.6%
Жонш	тонн	0.0	46,303.0	-
Бусад	тонн	856,432.4	599,959.0	29.9%

Зураг 2415 Автотээврийн импортын ачаа




Автотээврээр 2024 оны эхний хагас жилд нийт импортын ачааны 38%-ийг буюу нийт 1.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 31.4%-аар буурсан үзүүлэлт байна. Импортын тээврийн 83.4%-ийг БНХАУ-тай, 16.6%-ийг ОХУ-тай хиллэдэг боомтуудаар тээвэрлэжээ.

Үүнээс Замын-Үүд боомтоор хамгийн их буюу 975.9 мянган тонн оруулж ирсэн нь өмнөх оны мөн үеэс +33.7%-аар, Алтанбулаг боомтоор 100.8 мянган тонн оруулсан нь 21.25%, Цагааннуур боомтоор 75.2 мянган тонн оруулсан нь 19.5%, Боршоо боомтоор 23.8 мянган тонн ачаа оруулж ирсэн нь 64.8%, Хавирга боомтоор 18.2 мянган тонн оруулсан нь 10 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Ачаа тээвэр боомтуудаар	2023 он		2024 он	
	Импорт	Экспорт	Импорт	Экспорт
Нийт ачаа, тонн	1,751,143.0	28,775,754.0	1,201,520.2	40,607,866.5
Боршоо	14,440.0	0.0	23,794.0	0.0
Цагаан нуур	62,934.0	60,226.0	75,177.0	0.0
Сүмбэр	0.0	159.0	0.0	0.0
Хавирга	1,535.0	86,736.0	18,163.5	13,287.8
Алтанбулаг	83,112.0	27,888.0	100,766.0	20,120.0
Баянхошуу	6,797.0	621,684.0	3,751.7	218,311.0
Бургастай	20.0	136,480.0	280.0	278,518.4
Замын-Үүд	729,774.0	513,170.0	975,903.0	972,328.0
Бичигт	0.0	1,097,270.0	3,685.0	1,283,140.0
Булган	0.0	1,448,962.0	0.0	1,690,071.0
Ханги	581.0	2,310,599.0	0.0	3,990,537.3
Шивээ хүрэн	0.0	6,766,219.0	0.0	11,545,841.0
Гашуунсухайт	851,950.0	15,706,361.0	0.0	20,595,712.0
БНХАУ	1,590,657.0	28,687,640.0	1,001,783.2	40,587,746.5
ОХУ	160,486.0	88,114.0	199,737.0	20,120.0
Нийт	30,526,897.0		41,809,386.7	

Зураг 25 Боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгсэл, эзлэх хувь



Автозамын боомтуудаар 2024 оны эхний хагас жилд нийт 469,462 ачаатай тээврийн хэрэгсэл нэвтэрсэн бол үүнээс 81,234 тээврийн хэрэгсэл хилээр орсон, 388,228 тээврийн хэрэгсэл хилээр гарсан байна.


БНХАУ-тай хиллэдэг боомтуудаар нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо 455,331 болж өмнөх оноос 65.6%-аар нэмэгдсэн нь нийт хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийн 93.7%-ийг эзэлж байна.

ОХУ-тай хиллэдэг боомтуудаар 29,634 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оноос 64%-аар буурсан нь ОХУ-д болж буй зөрчилдөөнөөс шалтгаалан буурчээ.

Авто замн боомтуудаар нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн тоо	2023 он	2024 он	2024/2023
Орсон тээврийн хэрэгсэл	41,755	81,234.0	94.5%
БНХАУ-аас	31,920	67,103.0	110.2%
Бичигт	0	0.0	0.0%
Баянхошуу	306	192.0	-37.3%
Булган	551	0.0	-100.0%
Бургастай	3	9.0	200.0%
Гашуунсүхэйт	1,397	3,233.0	131.4%
Шивээхүрэн	219	21,821.0	9863.9%
Замын-Үүд	29,256	41,206.0	40.8%
Ханги	18	231.0	1183.3%
Хавирга	170	411.0	141.8%
ОХУ-аас	9,835	14,131.0	43.7%
Алтанбулаг	5,734	6,232.0	8.7%
Боршоо	647	1,027.0	58.7%
Цагааннуур	3,454	6,872.0	99.0%
Гарсан тээврийн хэрэгсэл	306,464	388,228.0	26.7%
БНХАУ-руу	233,597	372,725.0	59.6%
Бичигт	0	9,827.0	-
Баянхошуу	7,979	7,010.0	-12.1%
Булган	17,392	22,720.0	30.6%
Бургастай	2,498	8,757.0	250.6%
Гашуунсүхэйт	116,293	165,525.0	42.3%
Шивээхүрэн	54,203	90,848.0	67.6%
Замын-Үүд	2,738	23,502.0	758.4%
Ханги	31,577	44,174.0	39.9%
Хавирга	914	362.0	-60.4%
Сүмбэр	3	0.0	-100.0%
ОХУ-руу	72,867	15,503.0	-78.7%
Алтанбулаг	67,645	5,305.0	-92.2%
Боршоо	599	1,030.0	72.0%
Цагааннуур	4,623	9,168.0	98.3%

МОНГОЛ УЛСАД 1 270 278 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ БҮРТГЭЛТЭЙ БАЙНА.

Зураг 26 Тээврийн хэрэгслийн ангилал



Тээврийн хэрэгслийг хүрдний байрлалаар авч үзвэл баруун буюу буруу жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл 742,772 буюу 65.2%, зүүн буюу зөв жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл 396,797 34.8%-ийг эзэлж байна.

Эхний хагас жилд баруун хүрдтэй тээврийн хэрэгсэл өмнөх оны мөн үеэс 13.8%-аар, зүүн хүрдтэй тээврийн хэрэгсэл 8.9%-аар нэмэгджээ.

Монгол Улсад 2024 оны хагас жилийн байдлаар 1,270,278 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь өмнөх оноос 140,623 тээврийн хэрэгслээр буюу 12.4%-аар өссөн байна. Бүх төрлийн тээврийн хэрэгслийн өсөлтийн хувь ойролцоо байгаа нь ангилал тус бүрийн эзлэх хувьд өөрчлөлт оруулаагүй байна.

Хамгийн өндөр дүнгээр өссөн нь суудлын автомашин 96.9 мянгаар буюу 13%-аар өссөн бол хамгийн өндөр хувиар өссөн нь механизм 17%-аар буюу 11.8 мянгаар өссөн үзүүлэлт байна. Ачааны машин 14.7 мянгаар буюу 7.8%-аар өсчээ.

Зураг 2716 Жолооны хүрдний байрлал



Хөдөлгүүрийн төрөл



- Бензин	430,541
- Хосолсон	424,113
- Дизель	318,635
- Хийн	15,529
- Цахилгаан	1,302


Тээврийн хэрэгслийг хөдөлгүүрийн төрлөөр ангилбал, 36.2%-ийг бензин, 35.6%-ийг хосолсон, 26.8%-ийг дизель, 1.3%-ийг хийн түлштэй, 0.1%-ийг цахилгаан тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн тоо 1,302 болж өмнөх оны мөн үеэс 133 буюу 55.9%-аар өссөн нь хамгийн өндөр хувиар өссөн үзүүлэлт байна.


Нийт тээврийн хэрэгслийг хөдөлгүүрийн багтаамжаар нь ангилбал:

1500 см ³ хүртэл	360,627
1501-2500 см ³	496,443
2501-3500 см ³	152,227
3501-4500 см ³	47,221
4501 см ³	131,169

Зураг 28 Хөдөлгүүрийн багтаамж



Зураг 29 Автомашины насжилт



10 ба түүнээс дээш жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 1,007,383 бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 79.3% буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна.

0-3 жилийн насжилттай 82,826 тээврийн хэрэгсэл 6.5%, 4-6 жилийн насжилттай 56,698 тээврийн хэрэгсэл 4.5%,


7-9 жилийн насжилттай 123,372 тээврийн хэрэгсэл 9.7%-ийг тус тус эзэлж байна.

2023 онд автотээврийн хэрэгслийн улсын үзлэгт нийт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 72.2% буюу 861 мянган тээврийн хэрэгсэл хамрагдсан нь өмнөх оны хамрагдалтын хувиас 14.5%-аар илүү байна.

Улаанбаатар хотод 751,506 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 59%-ийг, орон нутагт 518,772 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 41%-ийг эзэлж байна.

Орон нутагт
41%
518 772

Улаанбаатарт
59%
751 506




	2023 он		2024 он		2024/2023
	Улсын хэмжээнд	Улсын хэмжээнд	Улаанбаатарт		
Нийт тээврийн хэрэгсэл	1,129,655	1,270,278	751,506		12.4%
Суудал	746,797	843,750	544,562		13.0%
Ачаа	188,611	203,397	88,367		7.8%
Автобус	21,696	23,813	13,122		9.8%
Тусгай	10,241	11,439	7,673		11.7%
Цистерн	3,971	4,569	3,203		15.1%
Зүтгүүр	45,560	51,925	28,491		14.0%
Механизм	16,362	19,142	13,503		17.0%
Чиргүүл	66,749	77,938	43,109		16.8%
Мотоцикл	29,668	34,305	9,476		15.6%
Жолооны хүрдний байрлал	1,017,170	1,139,569	685,991		12.0%
Баруун	652,766	742,772	474,169		13.8%
Зүүн	364,404	396,797	211,822		8.9%
Хөдөлгүүрийн төрөл	1,060,686	1,190,120	706,959		12.2%
Бензин	406,551	430,541	239,522		5.9%
Дизель	292,760	318,635	157,718		8.8%
Цахилгаан	835	1,302	1,169		55.9%
Газ	14,836	15,529	9,085		4.7%
Хосолсон	345,704	424,113	299,465		22.7%
Насжилт	1,129,656	1,270,279	751,507		12.4%
0-3	53,405	82,826	54,589		55.1%
4-6	48,568	56,698	30,806		16.7%
7-9	83,737	123,372	91,351		47.3%
10 ба түүнээс дээш	943,946	1,007,383	574,761		6.7%
Хөдөлгүүрийн багтаамж	1,059,823	1,187,687	705,070		12.1%
1500 см ³ хүртэл	341,011	360,627	192,699		5.8%
1501-2500 см ³	420,064	496,443	310,714		18.2%
2501-3500 см ³	136,741	152,227	89,091		11.3%
3501-4500 см ³	43,766	47,221	29,768		7.9%
4501 см ³ дээш	118,241	131,169	82,798		10.9%

Орон нутагт бүртгэлтэй тээврийн хэрэгслийг аймгуудаар задлан авч үзвэл, Өмнөговь аймагт 65,966 буюу 5.2%, Хөвсгөл аймагт 33,550 буюу 2.6%, Орхон аймагт 31,679 буюу 2.5%, Сэлэнгэ аймагт 31,085 буюу 2.4%, Дархан-Уул аймагт 29,368 буюу 2.3%, Өвөрхангай аймагт 28,613 буюу 2.25%, Дорноговь аймагт 28,435 буюу 2.24%, Баян-Өлгий аймагт 27,272 буюу 2.15%, Ховд аймагт 25,922 буюу 2%, Увс аймагт 22,646 буюу 1.8%, Төв аймагт 21,985 буюу 1.7%,

Дорнод аймагт 22,192 буюу 1.75%, Баянхонгор аймагт 21,338 буюу 1.7%, Архангай аймагт 20,999 буюу 1.7%, Хэнтий аймагт 20,377 буюу 1.6%, Завхан аймагт 18,783 буюу 1.48%, Сүхбаатар аймагт 18,196 буюу 1.4%, Булган аймагт 16,072 буюу 1.3%, Говь-Алтай аймаг 15,674 буюу 1.2%, Дундговь аймаг 14,310 буюу 1.1%, Говьсүмбэр 4,310 буюу 0.34% тээврийн хэрэгсэл эзэлж байна.


Зураг 30 Орон нутаг дахь тээврийн хэрэгслийн төрөл



БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР

2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ТӨМӨР ЗАМААР ОЛОН УЛСАД ЗОРЧИГЧДЫН ТОО 2.4 ДАХИН ӨСЛӨӨ.

Зураг 31 төмөр замын зорчигч




Зорчигч тээвэр

Төмөр замаар 2024 оны эхний хагас жилд нийт 921 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 14.3%-аар буурсан байна.

Олон улсад 19.5 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.4 дахин өссөн боловч орон нутагт 901.5 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 15.5%-аар буурч, төмөр замын зорчигч тээврийн хэмжээ буурахад нөлөөлжээ.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он		2024 он		2024/2023 %
		6 дугаар сар	Хагас жил	6 дугаар сар	Хагас жил	
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	224.9	1,074.9	195.5	921.0	-14.3%
Олон улс	мян.хүн	1.4	8.0	5.5	19.5	143.4%
Орон нутаг	мян.хүн	223.5	1,066.9	190.0	901.5	-15.5%
Зорчигч эргэлт	сая.хүн/км	82.0	384.5	79.0	382.8	-0.4%

Зураг 32 Төмөр замаар зорчсон зорчигчдын тоо, хоногоор



Зорчигчийн тоо өмнөх оноос 14.3%-аар буурахад Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам баригдаж хөдөлгөөн нээсэн, мөн төмөр замын зорчигч тээврийн тариф 50 хүртэл хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Төмөр замын тээврийн зорчигч эргэлт 2024 оны эхний хагас жилд 382.8 сая хүн км болж өмнөх оноос 0.4%-аар буурчээ.

Төмөр замаар 2024 оны эхний хагас жилд нийт 920,971 зорчигч зорчсон бол хоногт дундажаар 5,060 хүн тээвэрлэсэн байна.

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЧАА 21 САЯ ТОНН БОЛЖ 24 ХУВИАР ӨСЛӨӨ.

Зураг 33 Төмөр замын ачаа тээвэр17



Ачаа тээвэр

Төмөр замаар 2024 оны эхний хагас жилд нийт 21 сая тонн ачаа тээвэрлэж Ачаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24%-аар өсчээ.


2024 оны эхний хагас жилд экспортын ачаа 5.4 сая тонн болж өмнөх оноос 6.2%-аар буурсан боловч импортын ачаа 1.7 сая тонн болж өмнөх оноос 14.9%-аар, дотоодын ачаа 7.1 сая тонн болж өмнөх оноос 55.4%-аар, дамжин өнгөрөх ачаа 2.7 сая тонн болж өмнөх оноос 9.7%-аар тус тус өссөн байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны эхний хагас жил	2024 оны эхний хагас жил	2024/2023
Нийт ачаа тээвэр	мян.тн	16,972.7	21,043.2	24.0%
Дотоодын ачаа	мян.тн	7,108.1	11,047.7	55.4%
Импортын ачаа	мян.тн	1,706.7	1,960.2	14.9%
Экспорт ачаа	мян.тн	5,735.9	5,379.2	-6.2%
Дамжин өнгөрөх ачаа	мян.тн	2,422.0	2,656.0	9.7%
Ачаа эргэлт	сая.тонн/км	9,275.0	10,247.2	10.5%

Төмөр замын тээврийн нийт ачаа эргэлт 10,247.2 сая тонн км болж өмнөх оноос 10.5%-аар өсчээ.

Ачаа тээвэр, байгууллагаар	Хэмжих нэгж	2023 оны эхний хагас жил	2024 оны эхний хагас жил	2024/2023
Нийт ачаа тээвэр	мян.тн	16,972.7	21,043.2	24.0%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	15,908.7	15,938.5	0.2%
"Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	788.1	1,200.5	52.3%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	275.9	1,675.0	507.1%
"Монголиантранс Логистик" ХХК	мян.тн	-	1,837.0	-
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	-	522.2	-

